



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/6/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11





2.1. Оршил

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал **Д.Аюурзана** танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны **02 дугаар сарын 03-ны** өдрийн **01** дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан байгууллага айл өрхийн хог ачилт болон цэвэрлэгээг тогтмол хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд 10 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 34,500.0 мянган төгрөгөөс тооцон 690.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,260.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,940.1 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	933,3	933,3
Бараа материал	0,2	0,2	0.0
Үндсэн хөрөнгө	185,427.0	206,232.5	20,805.5
Элэгдэл	-28,656.7	-30,858.0	-2,201.3
Нийт хөрөнгө	214,083.9	238,024.0	23,940.1
Хуримтлагдсан ашиг	214,083.9	214,083.9	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	23,940.1	23,940.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	214,083.9	238,024.0	23,940.1

Бараа материалын дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй гараагүй. Бараа материалын дансны үлдэгдэл нь байгууллагын тамга болон туг бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогод авсантай холбоотой байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 238,024.0 мянган төгрөг болж 23,940.1 мянган төгрөгөөр өссөн байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь нийт 9,169.8 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 2,500.0 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6,000.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, хог цэвэрлэгээний орлого 669.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, гудамжны гэрэл цахилгаанд 2,500.0 мянган төгрөг, хог тээврийн автомашины засварт 6,000.0 мянган төгрөг, бараа материал худалдан авахад 139.0 мянган төгрөгийг зарцуулж, 530.8 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллахад анхаарах.



2.13. Шилэн дансны мэдээлэл

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдөж 100 хувь биелүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн төлөвлөгөөний талаар

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа алдагдах. Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төлөвлөгөө батлуулж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153 514,30	1 086 770,91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,30	933 270,91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,30	933 270,91
3121	Төгрөг	14,30	933 270,91
31213	Арилжааны банк дахь харилцах	14,30	933 270,91
35	БАРАА МАТЕРИАЛ	153 500,00	153 500,00
354	Хангамжийн материал	153 500,00	153 500,00
35420	Аж ахуйн материал	153 500,00	153 500,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	213 930 449,85	236 937 243,69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	213 930 449,85	236 937 243,69
392	Биет хөрөнгө	213 930 449,85	236 937 243,69
39201	Барилга, байгууламж, орон сууц	74 418 310,00	79 418 310,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32 699 604,98)	(34 995 127,31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22 932 500,00	28 932 500,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19 388 543,26)	(22 932 500,00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20 463 500,00	20 463 500,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(317 091,63)	(4 463 500,00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14 450 600,00	14 450 600,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8 210 360,00)	(13 565 600,00)
39209	Зам, гүүрийн байгууламж	224 486 152,00	267 350 992,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(82 205 012,28)	(97 721 931,00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	214 083 964,15	238 024 014,60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	214 083 964,15	238 024 014,60
51	Засгийн газрын хувь оролцоо	214 083 964,15	238 024 014,60
512	Хуримтлагдсан үр дүн	214 083 964,15	238 024 014,60
51210	Өмнөх үеийн үр дүн	284 984 545,15	214 083 964,15
51220	Тайлант үеийн үр дүн	(70 900 581,00)	23 940 050,45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	214 083 964,15	238 024 014,60

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	34 500 000,00	63 034 626,71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34 500 000,00	63 034 626,71
120	Нийтлэг татварын бус орлого	34 500 000,00	63 034 626,71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34 500 000,00	63 034 626,71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9 169 786,71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34 500 000,00	53 864 840,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29 001 091,00	39 094 576,26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29 001 091,00	39 094 576,26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29 001 091,00	39 094 576,26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	344 400,00	1 393 101,50
210301	Гэрэл, цахилгаан	344 400,00	1 393 101,50
2104	Хангамж, бараа материалын зардал	-	139 000,00
210401	Бичиг хэрэг	-	139 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6 673 400,00
210604	Урсгал засвар	-	6 673 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	31 028,60
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	31 028,60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28 656 691,00	30 858 046,16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28 656 691,00	30 858 046,16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5 498 909,00	23 940 050,45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76 399 490,00	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	76 399 490,00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(76 399 490,00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(70 900 581,00)	23 940 050,45



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	9 169 786,71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9 169 786,71
120	Нийтлэг татварын бус орлого	-	9 169 786,71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9 169 786,71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9 169 786,71
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	344 400,00	8 236 530,10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344 400,00	8 236 530,10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344 400,00	8 236 530,10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	344 400,00	1 393 101,50
210301	Гэрэл, цахилгаан	344 400,00	1 393 101,50
2104	Хангамж, бараа материалын зардал	-	139 000,00
210401	Бичиг хэрэг		139 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6 673 400,00
210604	Урсгал засвар		6 673 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	31 028,60
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		31 028,60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(344 400,00)	933 256,61
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(344 400,00)	933 256,61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	344 414,30	14,30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,30	933 270,91

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0,00	0,00	284 984 545,15	0,00	284 984 545,15
C07	Тайлант үеийн үр дүн			-70 900 581,00		-70 900 581,00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	214 083 964,15	0,00	214 083 964,15
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		0,00	214 083 964,15	0,00	214 083 964,15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	214 083 964,15	0,00	214 083 964,15
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	23 940 050,45	0,00	23 940 050,45
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	238 024 014,60	0,00	238 024 014,60

